ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ГАНТУЛГА ОВОГТОЙ ГЭРЭЛТУЯАГИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Зорилт 1. “Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх”<br>Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ. | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Төслийн санал боловсруулалтын хувь | 100% | 100% | Байгууллагын даргын 12 дугаар сарын 15-ны өдрийн А/468 дугаар тушаалаар байгуулсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, төлөвлөгөөний төсөлд зохион байгуулалтын нэгжээс ирүүлсэн саналуудыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох журмын дагуу нэгтгэв. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төсөлд саналыг боловсруулан 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд хүргүүлсэн.<br>Дээрх төслийг эрэмбэлэх зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яаманд 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт Мэдээллийн технологийн хэлтсийн даргын хамт оролцож, хүргүүлсэн саналын хүрээнд тайлбар, танилцуулга хийлээ. | 01-01 | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн, тайланг холбогдох газарт хүргүүлнэ. | Тайлан бэлтгэж хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь | - | 41% | Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг 2001-2023 оноор боловсруулж, 01 дүгээр сарын 22-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар болон байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст тус тус хүргүүлэв. | 01-06 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар батлагдсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын дагуу холбогдох хэсгийн 2024 оны 1 дүгээр улирлын танилцуулах мэдээг 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/659 дугаар албан бичгээр болон хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.<br><br>Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны 01, 02 дугаар сарын тайланг боловсруулан 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/484 дүгээр, 03 дугаар сарын тайланг 04 дүгээр сарын 02-ны өдрийн 02/696 дугаар албан бичгээр, 04 дүгээр сарын тайланг 05 дугаар сарын 03-ны өдөр, 05 дугаар сарын тайланг 06 дугаар сарын 06-ны өдөр цахим хаягаар тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.<br><br>Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны хагас жилийн тайланг боловсруулж, үнэлгээ хийлгэхээр 06 дугаар сарын 04-ний өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст тайлагнахаар мөн сарын 07-ны өдөр цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br><br>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам болон энэ төлөвлөгөөний дагуу хагас жилийн байдлаар хууль тогтоомжийн нийт 5 тайлан (41%) боловсруулахаас дээд шатны байгууллагаас хагас жилийн тайланг хугацаанаас өмнө тайлагнах чиглэл ирүүлсэн тул нийт 6 тайлан (50%) боловсруулж, үнэлгээ хийлгэн Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн болно. Мөн хууль тогтоомжид хамаарах бусад баримт бичгийн 2 тайланг боловсруулан тухай бүр хугацаанд нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг | Тайлан бэлтгэж хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь | - | 41% | "Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"-ийн 2023 оны тайланг 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01/91 дүгээр албан бичгээр болон цахим | 01-06 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгтгэн, тайланг холбогдох газарт хүргүүлнэ. | | | | хэлбэрээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br><br>“Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр"-ийн биелэлтийг 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/657 дугаар албан бичгээр болон хаягаар Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв.<br><br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны 01, 02 дугаар сарын тайланг боловсруулан 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/484 дугээр, 03 дугаар сарын тайланг 04 дүгээр сарын 02-ны өдрийн 02/696 дугаар албан бичгээр, 04 дүгээр сарын тайланг 05 дугаар сарын 03-ны өдөр, 05 дугаар сарын тайланг 06 дугаар сарын 06-ны өдөр тус тус цахим хаягаар тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.<br><br>“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны хагас жилийн тайланг тус тус боловсруулж, үнэлгээ хийлгэхээр 06 дугаар сарын 04-ний өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст тайлагнахаар мөн сарын 07-ны өдөр цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br><br>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам болон энэ төлөвлөгөөний дагуу хагас жилийн байдлаар бодлогын баримт бичгийн нийт 5 тайлан (41%) боловсруулахаас Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хагас жилийн тайланг хугацаанаас өмнө гаргуулан авах чиглэл ирүүлсэн тул нийт 7 тайлан (58%) боловсруулж, үнэлгээ хийлгэн хүргүүлсэн байна. Түүнчлэн бодлогын баримт бичигт хамаарах бусад хөтөлбөрийн 2 тайланг боловсруулан тухай бүр хугацаанд нь холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн байна. | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 1.4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг дээд шатны байгууллагад хүргүүлнэ. | Биелэлтийг тооцож, тайлан хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь | 100% | 41% | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн болон 05 дугаар сарын 15-ны өдрийн шуурхай хуралдаанд танилцуулах мэдээллийг бэлтгэн тухай бүр тус тус байгууллагын даргад биечлэн танилцуулж, 01 дүгээр сарын 23-ны өдрийн шуурхай хуралдаанаас ирүүлсэн үүргийн биелэлтийг хангуулан тайланг 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/378 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 05 дугаар сарын 15-ны өдрийн шуурхай хуралдаанд холбогдуулан тус яамнаас 06 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар үүрэг даалгавар ирүүлээгүй байна.<br><br>Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоогийн Сүхбаатар аймагт хийх айлчлалтай холбогдуулан байгууллагын үйл ажиллагааны 2020-2024 оны тайланг холбогдох чиглэлийн дагуу хураангуйлж боловсруулан Зүүн бүс дэх газраас Сүхбаатар аймаг дахь үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэж, товч танилцуулгыг 04 дүгээр сарын 26-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар хүргүүлсэн.<br><br>Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Засгийн газрын хуралдаанд мэдээлэл хийхтэй холбогдуулан байгууллагын сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн онцлох үйл ажиллагааны мэдээллийг боловсруулж, 05 дугаар сарын 07-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар хүргүүллээ.<br><br>Тайлант хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 3 удаагийн шуурхай үүргийн хүрээнд тайлан, мэдээг бэлтгэн хугацаанд нь хүргүүлж, тухай бүр биелэлтийг бүрэн хангаж ажиллав. | 01-05 | |
| 5. | Арга хэмжээ 1.5. Дээд шатны байгууллагаас батлах тогтоол шийдвэр, | Ирүүлсэн төсөлд санал боловсруулж хүргүүлсэн | 100% | 41% | "Цөмийн энергийн комисс"-ын 2024 оны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд саналыг боловсруулж, 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02/82 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | 01-05 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөр, үндсэн чиглэл болон хууль эрх зүйн чиглэлээс бусад баримт бичигт байгууллагаас тусгах саналын төслийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлнэ. | гүйцэтгэлийн хувь | | | Хууль зүй, дотоод хэргийн сайдын уулзалт зохион байгуулахтай холбоотой сайдын хэлэх үгийг бэлтгэн, байгууллагын даргад танилцуулж, саналыг 03 дугаар сарын 07-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яам д хүргүүлэн холбогдох асуудлаар мэдээлэл солилцлоо.<br><br>Байгууллагад ажиллаж буй орон тооны болон орон тооны бус зөвлөл, мэргэжлийн холбоодын талаарх мэдээлэл, холбогдох саналыг 03 дугаар сарын 26-ны өдөр ı хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br><br>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд тусгах арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулж, 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/673 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт хүргүүлэв.<br><br>Засгийн газрын 2023 оны "Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 178 дугаар тогтоолд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд саналыг 04 дүгээр сарын 09-ний өдрийн 02/747 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br><br>Монгол Улсын Ерөнхий сайд йн хилийн чанад дахь иргэдтэй хийсэн цахим уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний санал болон дараагийн уулзалтад иргэдийн зүгээс хөндөж болзошгүй асуудалд туссан ажлын биелэлтийг 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02/761 дүгээр албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүллээ.<br><br>Хагас жилийн байдлаар дээд шатны байгууллагаас санал авахаар ирүүлсэн төлөвлөгөөний төсөл болон мэдээлэлд тухай бүр хугацаанд нь саналыг боловсруулан хүргүүлсэн. | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | Арга хэмжээ 1.6. Байгууллагын үйл ажиллагааны сарын тайлангийн холбогдох тоон мэдээг нэгтгэн боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ. | Тоон мэдээ бэлтгэсэн гүйцэтгэлийн хувь | - | 41% | Байгууллагын 2023 оны 12 дугаар сарын үйл ажиллагааны тайлангийн тоон мэдээг боловсруулж, инфографик хэлбэрээр 12 дугаар сарын 15-ны өдрийн 02/2204 дүгээр албан бичгээр, 2024 оны 01 дүгээр сарын үйл ажиллагааны тайлангийн тоон мэдээг 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/291 дүгээр, 02 дугаар сарын тоон мэдээг 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/495 дугаар, 03 дугаар сарын тоон мэдээг 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/725 дугаар албан бичгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, байгууллагын цахим хуудаст нээлттэй байршуулсан.<br><br>Хууль зүй, дотоод хэргийн яамны 04 дүгээр сарын 12-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 4/1801 дүгээр албан бичгээр статистик мэдээллийн давхцалыг арилгах зорилгоор тоон мэдээг инфографик хэлбэрээр тус яаманд ирүүлэх шаардлагагүй гэсний дагуу 04 дүгээр сарын тоон мэдээг хүснэгтэн хэлбэрээр боловсруулж, 05 дугаар сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын тоон мэдээг 06 дугаар сарын 04-ний өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст баталгаажуулахаар тус тус хүргүүлж, мөн цахим хуудаст ил тод мэдээллээ.<br><br>Тайлант хугацаанд эхний 5 сар (41%)-ын тоон мэдээг боловсруулж, холбогдох байгууллага, нэгжид журамд заасан хугацаанд нь хүргүүлсэн байна. | 01-06 | |
| Зорилт 2. "Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах" Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдлийг боловсруулж, машин унших форматаар хувиргаж мэдээлнэ. | Өгөгдөл боловсруулж, системд байршуулсан гүйцэтгэлийн хувь | 100% | 41% | Мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 24-ний өдөр байгууллагын даргаар батлуулж, 2023 оны тайлангийн хамт 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01/237 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны сайд [illegible], 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/305 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. | 01-06 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-д баталсан, байгууллагад хамаарах мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдлөөс холбогдох журмын дагуу гадаадын иргэний зөвшөөрөл, бүртгэлийн 2024 оны 01, 02, 03, 04, 05 дугаар сарын 5 бүлгийн 8 нээлттэй өгөгдлийг тус тус XLSX өргөтгөлөөр, гадаадын иргэний зөвшөөрөл, бүртгэлийн болон гадаадын иргэний зөрчил, хяналтын 1 дүгээр улирлын нийт 6 бүлгийн 11 нээлттэй өгөгдлийг мөн өргөтгөлөөр тус тус боловсруулав.<br><br>Түүнчлэн 01, 02 дугаар сарын өгөгдлийг CSV, JSON, XML, 03 дугаар сар, 1 дүгээр улирлын өгөгдлийг CSV 04 дүгээр сарын өгөгдлийг CSV, JSON, 05 дугаар сарын өгөгдлийг CSV буюу машин унших форматаар тус тус хувирган боловсруулж, 01 дүгээр сарын өгөгдлийг 02 дугаар сарын 15-ны өдөр төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (хуучин)-д, 02 дугаар сарын өгөгдлийг 03 дугаар сарын 25-ны өдөр, 03 дугаар сар болон 1 дүгээр улирлын өгөгдлийг 04 дүгээр сарын 15-ны өдөр, 04 дүгээр сарын өгөгдлийг 05 дугаар сарын 14-ний өдөр, 05 дугаар сарын өгөгдлийг 06 дугаар сарын 06-ны өдөр тус тус шинэчлэгдсэн төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д баталсан хуваарийн дагуу нийтэллээ.<br><br>Төлөвлөгөөний дагуу энэ онд нийт 12 удаагийн өгөгдөл нийтлэхээс 5 удаа (эхний 5 сар)-ийн буюу нийт өгөгдлийн 41.6 хувийг хуулийн хугацаанд нь нийтэллээ. | | |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал хүргүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах | Хуулийн төсөлд танилцуулга, үзэл баримтлал хүргүүлсэн эсэх | - | 1 | Байгууллагын даргын 02 дугаар сарын 21-ний өдрийн А/74 дүгээр тушаалаар байгуулагдсан гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал хүргүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт 02 дугаар сарын 29-өөс 03 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл ажиллалаа.<br>Дээрх хугацаанд ажлын хэсгийн 2 удаагийн хурлыг байгууллагад зохион байгуулж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд танилцуулга, Гэр бүлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Харьяатын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд танилцуулга, үзэл баримтлалыг боловсруулан 03 дугаар сарын 07-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны ажлын хэсэг -т хүргүүлсэн. | 02-03 | |
| 2. | Арга хэмжээ 2. "Үндэсний хороо"-ны хурлаар хэлэлцүүлэх асуудалд санал боловсруулах | Санал боловсруулж хүргүүлсэн эсэх | - | 1 | Хилийн чанадаас эх орондоо эргэн суурьших Монгол Улсын иргэдэд чиглэсэн Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээг судлан хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүрэг бүхий "Үндэсний хороо"-ны анхдугаар хурлаар хэлэлцүүлэх асуудлын саналыг нэгтгэн боловсруулж, 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01/822 дугаар албан бичгээр болон цахим хаягаар Гадаад харилцааны яаманд хүргүүлэв. | 04-04 | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Арга хэмжээ 1. Төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтад хамрагдана. | Сертификатын огноо, дугаар | - | - | Удирдлагын академиас зохион байгуулж буй төрийн албан хаагчдад зориулсан "Ёс зүй" 3-р түвшний 12 цагийн цахим сургалтад хамрагдан дүүргэж, сертификатыг сургалт хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.<br>Сертификатын огноо, дугаар: 2024.03.27, yyl2zgu8fj | 03-03 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 2. Төрийн албан хаагчдад зориулсан богино хугацааны сургалтад хамрагдана. | Сертификатын огноо, дугаар | 1 | - | Удирдлагын академиас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх аргачлал” сэдэвт төрийн албан хаагчдад зориулсан богино хугацааны 16 цагийн сургалтад 03 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд суралцан төгсөж, сертификатыг сургалт хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэнд хуулбарлан өглөө.<br>Сертификатын огноо, дугаар: 24/0371 | 03-03 | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ........................ Г.ГЭРЭЛТУЯА 2024 оны 06 дугаар сарын 07

# ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ГАНТУЛГА ОВОГТОЙ ГЭРЭЛТУЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Зорилт 1. “Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх” Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ. | | | | | | | |
| - 1. | Арга хэмжээ 1.1. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд санал боловсруулж дээд шатны байгууллагад хүргүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | Төслийн санал боловсруулалтын хувь | 100% | 100% | Байгууллагын даргын 12 дугаар сарын 15-ны өдрийн А/468 дугаар тушаалаар байгуулсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, төлөвлөгөөний төсөлд зохион байгуулалтын нэгжээс ирүүлсэн саналуудыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох журмын дагуу нэгтгэв. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний төсөлд саналыг боловсруулан 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт хүргүүлсэн. (1 дүгээр улиралд төлөвлөж хугацаандаа бүрэн хэрэгжүүлсэн) Дээрх төслийг эрэмбэлэх зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яаманд 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт Мэдээллийн технологийн хэлтсийн даргын хамт оролцож, хүргүүлсэн саналын хүрээнд тайлбар, танилцуулга хийлээ. Түүнчлэн жилийн үйл ажиллагаанд төлөвлөгдөөгүй боловч дээд шатны байгууллагаас цаг үеийн шинжтэй үүрэг болгосон бодлогын баримт бичигт холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөний саналыг тухай бүр боловсруулж хүргүүлсэн. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хүргүүлэх санал боловсруулж, 08 дугаар сарын 06-ны | 01-09 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдрийн 01/1595 дугаар албан бичгээр, нэмэлт тайлбарыг 08 дугаар сарын 19-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдад тус тус хүргүүлсэн.<br>“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөлд тусгах саналыг холбогдох нэгжүүдээс нэгтгэн боловсруулж, 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/1920 дугаар албан бичгээр болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.<br>Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах “Ажлын хэсэг байгуулах тухай” А/524 дүгээр тушаалын төслийг боловсруулж, 11 дүгээр сарын 29-ний өдөр батлууллаа. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн, тайланг холбогдох газарт хүргүүлнэ. | Тайлан бэлтгэж хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь | - | 100% | Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны 01-10 дугаар сарын тайланг боловсруулан албан бичгээр боло цахим хаягаар тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.<br>Түүнчлэн хууль тогтоомжийн 2024 оны хагас жилийн тайланг 06 дугаар сарын 04-ний өдөр, жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 27-ны өдөр боловсруулж, үнэлгээ хийлгэхээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст, тайлагнахаар цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.<br>Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг 2001-2023 оноор боловсруулж, 01 дүгээр сарын 22-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар болон байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст тус тус хүргүүлэв.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05, 2024 оны 73 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу холбогдох хэсгийн 2024 оны улирлын танилцуулах мэдээг 03 дугаар сарын 28, 06 дугаар сарын 12, 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/659, 01/1224, 01/1910 дугаар албан бичгээр болон | 01-11 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.<br>Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2024 оны 24/03 дугаар тогтоолын тайланг 08 дугаар сарын 23-ны өдрийн 02/1678 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүйтэй холбогдуулан Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтээр тайланг ирүүлнэ гэсэн тул нэгтгэн боловсруулж, 11 дүгээр сарын 05-ны өдрийн 01/2190 дугаар албан бичгээр боло цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам болон энэ төлөвлөгөөний дагуу 2024 онд хууль тогтоомжийн холбогдох хугацааны тайланг бүрэн тайлагнаж ажиллав. Мөн хууль тогтоомжид хамаарах бусад баримт бичгийн 6 тайланг боловсруулан тухай бүр хугацаанд нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3.<br>Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн, тайланг холбогдох газарт хүргүүлнэ. | Тайлан бэлтгэж хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь | - | 100% | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хагас жилийн тайланг 06 дугаар сарын 04-ний өдөр, тоон утгад нэмэлт оруулсан тайланг 08 дугаар сарын 26-ны өдөр, жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 27-ны өдөр үнэлгээ хийлгэхээр тус тус Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст, тайлагнахаар цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны тайланг боловсруулж, үнэлгээ хийлгэхээр мөн 11 дүгээр сарын 27-ны өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.<br>“Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 01-10 дугаар сарын тайланг | 01-11 | |

18

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулан албан бичгээр болон цахим хаягаар тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жилийн тайланг 06 дугаар сарын 04-ний өдөр, жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 27-ны өдөр боловсруулж, тус тус Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.<br>"Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"-ийн 2023 оны тайланг 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01/91 дүгээр албан бичгээр болон цахим хэлбэрээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>"Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр"-ийн биелэлтийг 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/657 дугаар албан бичгээр болон хаягаар Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв.<br>"НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө"-ний Наймдугаар хэсэгт тусгагдсан "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах" чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 07 дугаар сарын 30-ны өдрийн 01/1534 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)"-ний хэрэгжилтийг боловсруулж, 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2240 дүгээр албан бичгээр болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.<br>"Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/2286 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам болон энэ төлөвлөгөөний дагуу 2024 оны тайланг холбогдох газруудад хүргүүлж, бүрэн тайлагнасан. Түүнчлэн бодлогын баримт бичигт хамаарах бусад хөтөлбөрийн 5 тайланг боловсруулан тухай бүр хугацаанд нь холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн байна.<br>Улаанбаатар хотноо 02 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Бүсчилсэн хөгжил-Монголын эдийн засгийн форум"-д 2 өдөр оролцов. | | |
| 4. | Арга хэмжээ 1.4.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг дээд шатны байгууллагад хүргүүлнэ. | Биелэлтийг тооцож, тайлан хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн болон 05 дугаар сарын 15-ны өдрийн шуурхай хуралдаанд танилцуулах мэдээллийг бэлтгэн тухай бүр тус тус байгууллагын даргад биечлэн танилцуулж, 01 дүгээр сарын 23-ны өдрийн шуурхай хуралдаанаас ирүүлсэн үүргийн биелэлтийг хангуулан тайланг 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/378 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдааны үүргийг тус яамнаас дахин ирүүлээгүй болно.<br>Монгол Улсын Ерөнхий сайд [illegible] ын хилийн чанад дахь иргэдтэй хийсэн цахим уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний санал болон дараагийн уулзалтад иргэдийн зүгээс хөндөж болзошгүй асуудалд туссан ажлын биелэлтийг 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02/761 дүгээр албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүллээ.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн "Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, дэг журмыг сайжруулах тухай" 1/5 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/1908 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэв.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэг даалгаврыг | 01-11 | |

82

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, 11 дүгээр сарын 07-ны өдөр байгууллагын даргаар батлуулан erp.e-mongolia.mn системд нийтэлсэн.<br>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд тусгах арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулж, 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/673 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт хүргүүлэв.<br>Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд йн Сүхбаатар аймагт хийх айлчлалтай холбогдуулан байгууллагын үйл ажиллагааны 2020-2024 оны тайланг холбогдох чиглэлийн дагуу хураангуйлж боловсруулан Зүүн бүс дэх газраас Сүхбаатар аймаг дахь үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэж, товч танилцуулгыг 04 дүгээр сарын 26-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар хүргүүлсэн.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Засгийн газрын хуралдаанд мэдээлэл хийхтэй холбогдуулан байгууллагын сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн онцлох үйл ажиллагааны мэдээллийг боловсруулж, 05 дугаар сарын 07-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар хүргүүллээ.<br>Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс Хууль зүй, дотоод хэргийн сайдад ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 09 дүгээр сарын 11-ний өдөр хаягт цахимаар хүргүүлсэн.<br>Тайлант хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай үүргийн хүрээнд болон эрх барих, гүйцэтгэх дээд шатны байгууллагаас сайдад хандаж ирүүлсэн саналын төсөл, тайлан, мэдээг бэлтгэн хугацаанд нь хүргүүлж, тухай бүр биелэлтийг бүрэн хангаж ажиллав. | | |

84

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Арга хэмжээ 1.5. Дээд шатны байгууллагаас батлах тогтоол шийдвэр, хөтөлбөр, үндсэн чиглэл болон хууль эрх зүйн чиглэлээс бусад баримт бичигт байгууллагаас тусгах саналын төслийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлнэ. | Ирүүлсэн төсөлд санал боловсруулж хүргүүлсэн гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | “Цөмийн энергийн комисс”-ын 2024 оны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд саналыг боловсруулж, 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02/82 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Байгууллагад ажиллаж буй орон тооны болон орон тооны бус зөвлөл, мэргэжлийн холбоодын талаарх мэдээлэл, холбогдох саналыг 03 дугаар сарын 26-ны өдөр хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2023 оны “Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 178 дугаар тогтоолд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд саналыг 04 дүгээр сарын 09-ний өдрийн 02/747 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>“Аялал жуулчлалын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд ашиглах нэг жилийн хугацаатай, олон удаагийн “БНХАУ-ын хилээр орох, гарах зорчих үнэмлэх”, гурван сарын хүчинтэй хугацаатай, нэг удаагийн, хил орчмын аялал жуулчлалын зориулалт бүхий “БНХАУ-ын орох, гарах зорчих үнэмлэх”-ээр Монгол Улсын хилээр нэвтэрч эхлэх хугацааны талаар саналыг 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1545 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>Төрөөс хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний судалгааг 08 дугаар сарын 30-ны өдрийн 02/1724 дүгээр албан бичгээр Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт хүргүүлэв.<br>Монгол Улсыг сурталчлах ажлыг холбогдох чиг үүргийн төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөнд саналыг 09 дүгээр сарын 19-ний өдрийн 01/1854 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | 01-11 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд саналыг боловсруулан 11 дүгээр сарын 22-ны өдрийн 02/2325 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>УИХ-ын чуулганы хугацаанд хэлэлцүүлэх хууль тогтоомжийн төсөл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 14 мега төсөл болон Засгийн газрын харьяа байгууллагуудын мэдээлэл сонсох хуваарьт саналыг 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/2353 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.<br>Тайлант хугацаанд дээд шатны байгууллагаас санал авахаар ирүүлсэн төлөвлөгөөний төсөл болон мэдээлэлд тухай бүр хугацаанд нь саналыг боловсруулан хүргүүллээ. | | |
| 6. | Арга хэмжээ 1.6. Байгууллагын үйл ажиллагааны сарын тайлангийн холбогдох тоон мэдээг нэгтгэн боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлнэ. | Тоон мэдээ бэлтгэсэн гүйцэтгэлийн хувь | - | 100% | Байгууллагын 2023 оны 12 дугаар сарын үйл ажиллагааны тайлангийн тоон мэдээг боловсруулж, инфографик хэлбэрээр 12 дугаар сарын 15-ны өдрийн 02/2204 дүгээр албан бичгээр, 2024 оны 01 дүгээр сарын үйл ажиллагааны тайлангийн тоон мэдээг 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/291 дүгээр, 02 дугаар сарын тоон мэдээг 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/495 дугаар, 03 дугаар сарын тоон мэдээг 04 дүгээр сарын 05-ны өдрийн 01/725 дугаар албан бичгээр албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, байгууллагын цахим хуудаст нээлттэй байршуулсан.<br>Хууль зүй, дотоод хэргийн яамны 04 дүгээр сарын 12-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 4/1801 дүгээр албан бичгээр статистик мэдээллийн давхцалыг арилгах зорилгоор тоон мэдээг инфографик хэлбэрээр тус яаманд ирүүлэх шаардлагагүй гэсний дагуу 04-11 дүгээр сарын тоон мэдээг хүснэгтэн хэлбэрээр боловсруулан журмын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст тухай бүр хүргүүлж, мөн цахим хуудаст ил тод мэдээллээ. | 01-11 | |

96

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 2. "Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах"<br>Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдлийг боловсруулж, машин унших форматаар хувиргаж мэдээлнэ. | Өгөгдөл боловсруулж, системд байршуулсан гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Мэдээлэл хариуцагчийн нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 24-ний өдөр байгууллагын даргаар батлуулж, 2023 оны тайлангийн хамт 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01/237 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд, 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/305 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.<br>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-д баталсан, байгууллагад хамаарах 6 бүлгийн 11 төрлийн нээлттэй өгөгдлийг XLSX болон XML, CSV, JSON өргөтгөл буюу машин унших формат (2024 оны 01-09 дүгээр сар хүртэлх)-аар тус тус боловсруулж, "Гадаадын иргэн, харьяатын газрын нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө"-ний дагуу байгууллагын цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д тухай бүр нийтэлсэн.<br>Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 96 дугаар тогтоолоор 2022 оны 232 дугаар тогтоолыг хүчингүй болгож, "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-ыг шинэчлэн баталснаар уг жагсаалтын дагуу 10 дугаар сарын мэдээлэл хариуцагчийн сар бүр нийтлэх 11 төрлийн өгөгдлийг XLSX, CSV, JSON өргөтгөлөөр тус тус боловсруулж, 11 дүгээр сарын 15-ны өдөр байгууллагын цахим хуудас болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (opendata.gov.mn)-д төлөвлөгөөнд заагдсан хугацаанд нийтэллээ.<br>Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой цаг үеийн мэдээ, хууль тогтоомж, тоон мэдээлэл, нээлттэй мэдээлэл, нээлттэй өгөгдлийг хүлээн авах сувгуудын мэдээллийг 10 дугаар сарын 31-ний өдрийн 01/2141 дүгээр албан бичгээр Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын БНХАУ дахь төлөөлөгчийн газарт хүргүүлсэн. | 01-11 | |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Арга хэмжээ 1. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал хүргүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах | - | - | - | Байгууллагын даргын 02 дугаар сарын 21-ний өдрийн А/74 дүгээр тушаалаар байгуулагдсан гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал хүргүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт 02 дугаар сарын 29-өөс 03 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл ажиллалаа. Дээрх хугацаанд ажлын хэсгийн 2 удаагийн хурлыг байгууллагад зохион байгуулж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд танилцуулга, Гэр бүлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Харьяатын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд танилцуулга, үзэл баримтлалыг боловсруулан 03 дугаар сарын 07-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны ажлын хэсэг ·т хүргүүлсэн. | 02-03 | |
| 2. | Арга хэмжээ 2. “Үндэсний хороо”-ны хурлаар хэлэлцүүлэх асуудалд санал боловсруулах | - | - | - | Хилийн чанадаас эх орондоо эргэн суурьших Монгол Улсын иргэдэд чиглэсэн Засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээг судлан хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүрэг бүхий “Үндэсний хороо”-ны анхдугаар хурлаар хэлэлцүүлэх асуудлын саналыг нэгтгэн боловсруулж, 04 дүгээр сарын 19-ний өдрийн 01/822 дугаар албан бичгээр болон цахим хаягаар Гадаад харилцааны яаманд хүргүүлэв. | 04-04 | |
| 3 | Арга хэмжээ 3. Байгууллагын үйл ажиллагааны холбогдох хугацааны тайлан, төлөвлөгөө боловсруулж батлуулах, үнэлүүлэх | - | - | - | Байгууллагын үйл ажиллагааны 08 дугаар сарын төлөвлөгөөнд тусгах саналыг зохион байгуулалтын нэгжүүдээс нэгтгэн боловсруулж, байгууллагын даргаар 07 дугаар сарын 31-ний өдөр батлуулан 08 дугаар сарын 01-ний өдөр Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-ээр албан хаагчдад танилцуулсан. | 07-09 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | (Орлон ажилласан) | | | | Байгууллагын үйл ажиллагааны 07 дугаар сарын тайланг нэгтгэн боловсруулж, үнэлгээ хийлгэхээр 08 дугаар сарын 06-ны өдөр, 08 дугаар сарын тайланг нэгтгэн боловсруулж, 09 дүгээр сарын 04-ний өдөр тус тус Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст хүргүүлсэн.<br>07 дугаар сарын тайлангийн хэрэгжилт 96.6 хувьтай, 08 дугаар сарын тайлангийн хэрэгжилт 94,2 хувьтай үнэлэгдсэн байна. Мөн байгууллагын өргөдөл, гомдлын 08 дугаар сарын мэдээг хянав. | | |
| 4 | Арга хэмжээ 4.<br>Идлэг шонхор шувуу баригч гадаадын иргэдэд олгосон визийн талаар танилцуулга боловсруулах | - | - | - | Байгууллагын даргын шуурхай үүрэг болгосноор соёлын зориулалтаар гаргах идлэг шонхор шувуу баригч гадаадын иргэдэд олгосон визийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулга боловсруулж, 09 дүгээр сарын 26-ны өдөр хүргүүллээ. | 09-09 | |
| 5 | Арга хэмжээ 5.<br>Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем (ISM)-ийн доголдлын талаар танилцуулга боловсруулах | - | - | - | Байгууллагын даргын шуурхай үүрэг болгосноор Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем (ISM)-ийн доголдлын талаар Хууль зүй, дотоод хэргийн сайдад танилцуулга боловсруулж, 11 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн. | 10-10 | |
| 6 | Арга хэмжээ 6.<br>Бусад | - | - | - | Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх "Залуучуудын хөгжлийн зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд ажиллах албан хаагчийн мэдээллийг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/362 дугаар албан бичгээр болон хаягт хүргүүллээ.<br>Баримт бичгийн хуурмаглалтай тэмцэх тоног төхөөрөмжийн ач холбогдлын талаар Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагад хүргүүлэх танилцуулгын найруулгыг засварлан боловсруулж, Гадаад харилцаа, судалгаа, хамтын ажиллагааны хэлтэст 05 дугаар сарын 07-ны өдөр илгээсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдаа дэмжих төсөл"-ийн Барилга хяналтын гүйцэтгэлийн зөвлөх компани болон Хавирга боомтын барилга угсралтын ажлын тендерийн баримт бичгийг боловсруулах "Үнэлгээний хороо"-д ажиллах албан хаагчийн мэдээллийг 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1550 дугаар албан бичгээр Боомтын сэргэлтийн үндэсний хороонд хүргүүллээ.<br>Хүн амын тооллогын 32 дугаар олон улсын бага хуралд оролцуулах тухай мэдээллийг 08 дугаар сарын 09-ний өдөр Үндэсний статистикийн хороонд цахим хаягаар хүргүүлсэн.<br>Монгол улсаас орогнол хүссэн болон тус улсад оршин сууж байгаа харьяалалгүй хүний мэдээллийг 09 дүгээр сарын 16-ны өдрийн 02/1820 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яаманд уламжлууллаа.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллах "Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл"-ийн бүрэлдэхүүнд ажиллах албан хаагчийн мэдээллийг 10 дугаар сарын 03-ны өдрийн 01/1966 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга ɪд хүргүүлсэн.<br>Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй болон хадгалагдсан соёлын өв, дүрслэх урлагийн бүтээл, бэлэг дурсгал, эд өлгийн зүйлсийн мэдээллийг 10 дугаар сарын 22-ны өдрийн 02/2083 дугаар албан бичгээр Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлсэн.<br>Стандартчиллын 2025-2026 оны төлөвлөгөөнд саналыг 11 дүгээр сарын 28-ны өдрийн 02/2354 дүгээр албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн. | | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалтад хамрагдана. | Сертификатын огноо, дугаар | - | 1 | Удирдлагын академиас зохион байгуулж буй төрийн албан хаагчдад зориулсан “Ёс зүй” 3-р түвшний 12 цагийн цахим сургалтад хамрагдан дүүргэж, сертификатыг сургалт хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.<br>Сертификатын огноо, дугаар: 2024.03.27, yyl2zgu8fj | 03-03 | |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Төрийн албан хаагчдад зориулсан богино хугацааны сургалтад хамрагдана. | Сертификатын огноо, дугаар | 1 | 1 | 1. Удирдлагын академиас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх аргачлал” сэдэвт төрийн албан хаагчдад зориулсан богино хугацааны 16 цагийн сургалтад 03 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд суралцаж дүүргэв.<br>Сертификатын огноо, дугаар: 24/0371<br>2. Статистикийн үндэсний хорооноос зохион байгуулсан “Эксел программын хэрэглээний анхан болон дунд түвшний хөтөлбөр”-т 10 дугаар сарын 07-оос 10-ны өдрүүдэд хамрагдлаа.<br>Сертификатын огноо, дугаар: Excel/ТБ-41<br>3. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх “Ахлах түшмэлийн багц сургалт”-д 09 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн Удирдлагын Академид суралцаж байна.<br>4. Эрх зүйн бакалавр эзэмших сургалтад 09 дүгээр сараас эхлэн Орхон их сургуульд суралцаж байна. | 03-11 | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ........................ Г.ГЭРЭЛТУЯА 2024.12.02